

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ДАРХАН-УУЛ АЙМГИЙН 2017 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН



Дархан-Уул аймаг
ДААТАГ-2018/03-ГА

Агуулга

Тайланг бэлтгэсэн:

Аймгийн Аудитын газар

Тэргүүлэх аудитор

Ч.Чүлтэмбат

Аудитын менежер

Ш.Мөнхбаяр

Ахлах аудитор

Х.Сувдмаа

Аудитор

У.Батсүрэн

2018 оны 4 дүгээр сар

Аудитын тайлантай холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 7037-3089, 7037-8845, 7037-8142 дугаарын утсаар харилцана уу.

ХАЯГ:

*Аймгийн аудитын газар
Аймгийн ЗДТГ-ын байр
Дархан-Уул аймаг
Монгол Улс*

Товчилсон үгийн жагсаалт	2
Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	3

Бүлэг 1

Төсвийн орлого, зарлагын төлөвлөлт	5
Төсвийн орлого	7
Төсвийн зарлага	10
Төсвийн тэнцэл	12
Нэмэлт санхүүжилт	12
Тусгай зориулалтын шилжүүлэг	13
Улсын төсвийн хөрөнгө оруулалт	14
Шилэн дансны хэрэгжилт	15
Дүгнэлт	16
Зөвлөмж	16
Холбогдох байгууллагын санал	17
Тайлан баталгаажуулсан тушаал	18

Товчилсон үгийн жагсаалт

УИХ	Улсын их хурал
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ЗГ	Засгийн газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ОУ	Олон улс
ЭМТ	Эрүүл мэндийн төв
ТЗШ	Тусгай зориулалтын шилжүүлэг
АТБӨЯХТ	Авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн татвар
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
НААҮГ	Нийтийн аж ахуй үйлчилгээний газар
ДААТАГ	Дархан-Уул аймгийн Төрийн аудитын газар
ГА	Гүйцэтгэлийн аудит
ЗГНХ	Засгийн газрын нөөц хөрөнгө
СХС	Сум хөгжүүлэх сан
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
ГХБХБГ	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
БАҮ	Бараа ажил үйлчилгээ

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Үндэсний аудитын газрын нэгдсэн төлөвлөгөөг үндэслэн Монгол Улсын Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлогдсон аймгийн Аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд аудитыг хийлээ.

Аудитын зорилт

Дархан-Уул аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн орон нутгийн нэгдсэн төсвийн болон тусгай шилжүүлгийн гүйцэтгэл үнэн зөв илэрхийлэгдсэн эсэхэд аудит хийж, дүгнэлт, зөвлөмж боловсруулан дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдсэн болно. Үүнд:

- Нэгдсэн төсвийн орлого, зарлагын төлөвлөлт
- Нэгдсэн төсвийн орлого
- Нэгдсэн төсвийн зарлага
- Төсвийн тэнцэл
- Нэмэлт санхүүжилт
- Тусгай зориулалтын шилжүүлэг
- Улсын төсвийн хөрөнгө оруулалт

Хамарсан хүрээ

Аудитаар орон нутгийн нэгдсэн төсвийн болон тусгай зориулалтын шилжүүлгийн төлөвлөгөө, гүйцэтгэл, аймаг, сумдын ИТХ, Санхүү төрийн сангийн хэлтсийн холбогдох данс, санхүүгийн тайлан, судалгаа, аймгийн Аудитын газрын санхүүгийн аудитын тайлан, материалд тулгуурлан 2017 оны үйл ажиллагааг хамруулав.

Үндсэн мэдээлэл

2017 онд аймгийн орон нутгийн нийт орлогыг 71.5 тэрбум төгрөгөөр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 68.2 тэрбум төгрөг төвлөрч төлөвлөгөө 3.3 тэрбум төгрөгөөр дутуу биелжээ.

Харин 2017 оны төсвийн нийт зарлага 71.2 тэрбум төгрөгөөр батлагдсанаас 64.4 тэрбум төгрөгийг зарцуулж, батлагдсан төсвийг 6.8 тэрбум төгрөгөөр хэмнэсэн байна.

Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхдээ Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын арга зүйг ашиглан, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, баримт материалтай танилцах, тайлан баримт материалыг тулган баталгаажуулах, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглахын зэрэгцээ аудитын судалгаа, хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж, ажлын баримт материалд хавсаргав.

Шалгуур үзүүлэлт

Дараах хууль эрхийн актыг аудитын шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглалаа. Үүнд:

- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Монгол улсын 2017 оны төсвийн тухай хууль
- Монгол улсын 2017 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль
- Төрийн аудитын тухай хууль
- Сангийн сайдын 2013 оны 73 тоот тушаалаар баталсан журам
- Аймаг, сумдын ИТХ-ын 2017 оны төсөв, тодотгол баталсан тогтоолууд
- Холбогдох бусад хууль эрхийн актууд

Бүлэг 1

**Төсвийн орлогыг 10.6 тэрбум, зарлагыг 10.7 тэрбум
төгрөгөөр баталсан байна.**

1.1. Монгол Улсын Их Хурлын 2016 оны 11 дүгээр сарын 10-ний өдрийн хуралдаанаар баталсан Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуулиар Дархан-Уул аймгийн орон нутгийн төсвийн суурь орлогыг 15,192.4 сая, суурь зарлагыг 14,516.6 сая, тусгай зориулалтын шилжүүлгийг 33,642.9 сая, орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийг 1,773.3 сая, улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг 270.3 сая, ТЗШ-ийн байгууллагуудын өөрийн орлогыг 101.4 сая төгрөгөөр тус тус баталжээ.

Аймгийн орон нутгийн төсвийн төслийг Төсвийн тогтвортой байдлын тухай, Төсвийн тухай, Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуулиудийн холбогдох заалт, тусгай шаардлагууд, зарчмууд болон Засгийн газрын “Орон нутгийн төсвийн аргачлал” батлах тухай 2012 оны 30, Төсвийг хэмнэлтийн горимд шилжүүлэх зарим арга хэмжээний тухай” 2014 оны 147 дугаар тогтоолууд, Сангийн сайдын “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам” батлах тухай 2012 оны 244, “Төсвийн зарим анхдагч ангилал батлах тухай” 2014 оны 150 дугаар тушаалууд, нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын гаргасан тогтоол, шийдвэр, “Аймгийн Засаг даргын 2014-2017 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, Сангийн сайдын 2016 оны 11 сарын 18-ны өдрийн 3-1/6535, 2017 оны 4-1/2168, 4-1/6303 тоотуор ирүүлсэн 2017 оны орон нутгийн төсвийн төсөл боловсруулах чиглэлийг тус тус удирдлага болгон боловсруулж, аймаг, сумдын ИТХ-аар баталсан байна.

/сая.төг-өөр/

Үзүүлэлт	УИХ-аас баталсан төсөв	Аймаг, сумдын ИТХ- аар баталсан төсөв	Зөрүү
Төсвийн орлого	15,192.4	25,794.6	10,602.2
Төсвийн зарлага	14,516.6	25,225.2	10,708.6
Орлогын шилжүүлэг /ОНХС/	1,773.3	2,870.4	1,097.1
Тусгай зориулалтын шилжүүлэг	33,642.9	33,967.9	325.0
Төвлөрүүлэх орлого	270.3	270.3	
ТЗШ-ийн байгууллагуудын өөрийн орлого	101.4	217.8	116.4

Эдийн засгийн төлөв байдалд тулгуурлан 2017 оны төсвийн орлогын төлөвлөгөөг төсвийн тэнцвэртэй байдлыг баримтлах, орон нутгийн хэмжээнд татвар төлбөр хураамжийн тогтвортой орчинг хангах, хүчин төгөлдөр мөрдөгдөж буй татварын хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулах зарчмыг баримтлан төсвийн орлогыг 10,602.2 сая төгрөгөөр нэмэгдүүлжээ. Үүнд:

- Орон нутгийн төсвийн орлогыг нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагаас хуулиар олгогдсон зарим татварын хувь хэмжээг өсгөж тогтоосон тогтоол болон

төсвийн хүлээгдэж буй гүйцэтгэлийг үндэслэн, газрын дуудлага худалдааны орлогыг 318.0 сая, цалин хөлс түүнтэй адилтгах орлогын албан татварыг 1,386.9 сая, хүү торгуулийн орлогыг 100.0 сая, үл хөдлөх хөрөнгийн татварыг 646.0 сая, АТӨЯХАТ-ыг 165.0 сая, улсын тэмдэгтийн хураамжийг 50.0 сая, газрын төлбөрийн орлогыг 159.3 сая, газрын дуудлага худалдааны орлогыг 50.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн нэмэлт эх үүсвэрийг бий болгосон байна.

Мөн хувь хүний орлогын албан татварын хадгаламжийн хүүгийн орлогоор Дархан сумын төсвийн орлогыг 272.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж, сумын төсвөөс аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг 866.7 сая төгрөг байхаар, Шарын гол сумын төсвийн орлогыг хүлээгдэж буй гүйцэтгэлд үндэслэн 26.2 сая төгрөгөөр нэмэгдүүлж, аймгийн төсвөөс суманд олгох санхүүгийн дэмжлэгийг 16.2 сая төгрөгөөр бууруулжээ.

1.2. 2017 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээрх зайлшгүй зардлыг нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын гаргасан тогтоол, шийдвэр, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд орлогын эх үүсвэрийн боломжинд тулгуурлан зарим байгууллагын зардлаас хасч, нэмж зохицуулалт хийсэн байна. Тухайлбал:

- НААҮГ-аас 9.9 сая, хүүхдийн зуслангаас 25.1 сая, байгаль орчныг нөхөн сэргээх зардлаас 75.8 сая төгрөгийг тус тус бууруулсан бол
- Аймгийн ИТХ-ын төсвийг 6.2 сая, ЗДТГ-т 29.9 сая, орон нутгийн нөөц хөрөнгийн 221.5 сая, Байгаль орчны аялал жуулчлалын газрын төсвийг 2.1 сая, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг 227.2 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн баталжээ.

1.3. Аймгийн ИТХ нь орон нутгийн төсвийг батлахдаа Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.1¹, 34.2.2², 34.2.3³ дахь заалтыг мөрдөхгүйгээр 2017 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 6/01 тоот тогтоолоор 2017 оны анх батлагдсан дүнгээс орон нутгийн төсвийн нийт орлого, зарлагыг 4,702.6 сая төгрөг буюу 7.9 хувиар, 2017 оны 10 дугаар 02-ны өдрийн 8/01 тоот тогтоолоор 0.4 сая төгрөг буюу 0.6 хувиар тус тус нэмэгдүүлж тодотгосон байв.

Орон нутгийн төсвийг баталсан тодотголуудаас 5, 12 дугаар саруудад хийсэн тодотгол нь “Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль”-тай холбогдуулан тодотгожээ.

Түүнчлэн аймгийн ИТХ-ийн 2017 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 9/05 тоот тогтоолоор нийгмийн халамжийн тэтгэмжийг 463.7 сая төгрөгөөр нэмж тодотгосон ч тус сангийн мөнгөн хөрөнгө 489.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан нь нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн зардлын төлөвлөлт нь тооцоо, судалгаа хангалтгүй, үндэслэлгүй хийгдсэнийг харуулж байна.

¹ дээд шатны төсөвт тодотгол хийсний улмаас тухайн шатны төсөвт тодотгол хийх зайлшгүй шаардлага бий болсон;

² урьдчилан тооцох боломжгүй нөхцөл байдлын улмаас төсвийн орлого буурах, зарлага нэмэгдэж, орон нутгийн төсөв алдагдалтай болох нөхцөл байдал бий болсон;

³ энэ хуулийн 29.7-д заасан үндэслэл бий болсон тохиолдолд батлагдсан хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төсөвт өртөгт өөрчлөлт оруулах

Бүлэг 2

Орон нутгийн төсвийн орлогыг 2.8 хувиар давуулан биелүүлсэн ч зарим албан татвар 10.8-18.5 хувиар тасарсан байна.

2.1. Аймгийн ИТХ нь 2017 онд орон нутгийн төсөвт 4 удаа тодотгол хийж, 2017 оны Төсвийн тухай хуулиар батлагдсан төсвөөс нийт орлогыг 12,418.9 сая төгрөгөөр өсгөж, 71,504.4 сая төгрөгөөр тодотгон баталсан байна.

Төсвийн нийт орлогын гүйцэтгэлийг хүснэгтээр үзүүлбэл:

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	2017 он				Хувь
		Анх батлагдсан	Тодотгосон төсөв	Гүйцэтгэл	Зөрүү	
		2	3	4	5=4-3	
Б	1					
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	60 407,5	59 085,5	71 504,4	68 197,5	(3 306,9)	95,4
НИЙТ ОРЛОГО	19 479,1	18 622,7	21 671,4	22 202,7	531,3	102,5
УРСГАЛ ОРЛОГО	19 479,1	18 622,7	21 671,4	22 202,7	531,3	102,5
Татварын орлого	17 598,6	16 776,2	19 746,3	20 064,7	318,4	101,6
Татварын бус орлого	1 880,5	1 846,5	1 925,1	2 138,0	212,9	111,1
ТУСЛАМЖИЙН ОРЛОГО	38 933,2	40 462,8	46 187,1	43 153,7	(3 033,4)	93,4
ОН-ийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	4 108,2	1 946,4	1 773,3	1 773,3	-	100,0
Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг	1 742,9					-
Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	31 927,4	32 923,3	33 967,8	33 967,9	0,1	100,0
ТЗШ-ээр санхүүжих байгууллагын өөрийн орлого	215,8	136,9	217,8	232,4	14,6	106,7
Бусад тусламж				464,0	464,0	
Гадаадын төслийн зээлээс	938,9	5 456,2	10 228,2	6 716,1	(3 512,1)	65,7
ОНЫ ЭХНИЙ ҮЛДЭГДЛЭЭС	1 995,1		3 645,9	2 841,1	(804,8)	77,9

Нийт орлогын гүйцэтгэл 2017 онд 68,197.5 сая төгрөгт хүрч, анх батлагдсан төсвөөс 15.4 хувь буюу 9,112.0 сая төгрөгөөр илүү, тодотгосон төсвөөс 4.6 хувь буюу 3,306.9 сая төгрөгөөр дутуу биелсэн бол өмнөх оны гүйцэтгэлээс 12.9 хувь буюу 7,790.0 сая төгрөгөөр дутуу төвлөрсөн байна. Энэ нь гадаадын төслийн зээлээс санхүүжих орлого 65.7 хувиар буюу 3,512.1 сая төгрөгөөр дутуу санхүүжсэнтэй холбоотой байна. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан, ТЗШ-ийн байгууллагын санхүүжилт төлөвлөгөөний дагуу бүрэн хийгджээ.

2.2. Аймгийн хэмжээнд орон нутгийн төсвийн орлого 22,202.7 сая төгрөгт хүрч орлогын төлөвлөгөө 616.3 сая төгрөгөөр буюу 2.8 хувиар давуулан биелснээс татварын орлого 521.4 сая, татварын бус орлого 94.9 сая төгрөгөөр тус тус давж, биелсэн байна. Татварын орлого нийт дүнгээр биелсэн боловч зарим орлогын биелэлт хангалтгүй байв.

Улс орны эдийн засгийн хүндрэлтэй нөхцөл байдлын улмаас ипотекийн зээлийн хэмжээ буурсан, хөрөнгө борлуулсны орлогын албан татвар, газрын төлбөрийн өр барагдаагүй, бууны албан татварын орлого, улсын тэмдэгтийн хураамж 10.8-18.5 хувиар тус тус тасарсан нь нөлөөлжээ.

2.3. Түүнчлэн тайлант онд сум хөгжүүлэх сангийн орлого 988.3 сая төгрөгөөр төлөвлөгдсөнөөс 842.8 сая төгрөгийн орлого оржээ. Тус сангийн орлого 85.3 хувиар буюу 145.5 сая төгрөгөөр дутуу буюу биелсэн байна. Тайлант онд сум хөгжүүлэх сангийн зээлэнд 535.1 төгрөгийг олгож, оны эцэст сумын төсвийн нэгдсэн дансанд 307.7 сая төгрөгийг татан төвлөрүүлжээ.

Сум хөгжүүлэх сангийн зээлийг олгосноор орон нутагт санхүүгийн эрх мэдэл олгогдсон, арилжааны банкаар дамжуулахгүй олгож байгаа нь иргэдэд чирэгдэлгүй болсон, сумдын удирдлага жижиг дунд үйлвэрлэлийг дэмжих идэвхи сайжирч, иргэдийн санал санаачлага нэмэгдсэн, иргэд бие биедээ хяналт тавих нөхцөл бүрдсэн зэрэг давуу талууд бий болсон ч СХС-ийн орлогын эх үүсвэр болох зээлийн үндсэн төлбөр, хүүгийн төвлөрүүлэлт муу байгаа нь ажил хариуцсан холбогдох албан тушаалтнууд зээлийн эргэн төлүүлэх талаар санаачлагагүй ажилласантай холбоотой байна.

Орон нутгийн төсвийн орлогын гүйцэтгэлийг сумдаар авч үзвэл:

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/сая.төг-өөр/	
			Зөрүү	Хувь
Аймаг	18 134,2	18 800,5	666,3	103,7
Татварын орлого	17 093,0	17 543,6	450,6	102,6
Татварын бус орлого	1 041,2	1 256,9	215,7	120,7
Дархан сум	2 767,1	2 727,5	- 39,6	98,6
Татварын орлого	2 356,6	2 178,5	- 178,1	92,4
Татварын бус орлого	410,5	549,0	138,5	133,7
Шарын гол сум	300,4	279,0	- 21,4	92,9
Татварын орлого	141,4	151,5	10,1	107,1
Татварын бус орлого	159,0	127,5	- 31,5	80,2
Хонгор сум	324,7	245,1	- 79,6	75,5
Татварын орлого	108,6	138,2	29,6	127,3
Татварын бус орлого	216,1	106,9	- 109,2	49,5
Орхон сум	145,0	150,6	5,6	103,9
Татварын орлого	46,7	52,9	6,2	113,3
Татварын бус орлого	98,3	97,7	- 0,6	99,4

Дархан-Уул аймаг: Аймгийн төсөвт төвлөрүүлсэн татварын болон татварын бус орлого 104.0 хувиар биелсэн хэдий ч улсын тэмдэгтийн хураамжийн орлого 86.0 сая төгрөгөөр тасарсан байна.

Дархан сум: Сумын төсвийн орлого нийт дүнгээр 39.6 сая төгрөгөөр буюу 1.4 хувиар тасарснаас ус рашаан нөөц ашигласны төлбөр 122.4 сая төгрөгөөр буюу 16.1 хувиар, бууны албан татвар 11.5 сая төгрөгөөр буюу 56.9 хувиар тус тус тасарчээ.

Шарын гол сүм: Тус сумын орлого 12.8 сая төгрөгөөр тасарснаас үйл ажиллагааны орлого 35.3 хувиар, улсын тэмдэгтийн хураамж 22.8 хувиар, байгалийн нөөц ашигласны төлбөр 5.9 хувиар, ойн нөөц ашигласны төлбөр 40.9 хувиар тус тус тасарсан байна. Харин суутган тооцсон татварын орлого 10.5 сая төгрөгөөр буюу 16.0 хувиар, хөрөнгө борлуулсаны орлого 5.0 сая төгрөгөөр буюу 90.7 хувиар тус тус давжээ. Тайлант онд хэрэглээний мод бэлтгэлийн хэмжээ багассан нь улсын тэмдэгтийн хураамж, ойн нөөц ашигласны төлбөрийн орлого, байгалийн нөөц ашигласны төлбөр буурахад нөлөөлжээ.

Хонгор сүм: Тус сумын төсвийн орлогыг 324.7 сая төгрөг төлөвлөснөөс гүйцэтгэлээр 245.1 сая төгрөг төвлөрч, орлого 79.6 сая төгрөгөөр буюу 24.5 хувиар тасарчээ. Тухайлбал: Хөрөнгө борлуулсаны орлого, улсын тэмдэгтийн хураамжийн орлого 2.6-5.6 хувиар, бууны албан татвар 23.6 хувиар, хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлого 51.8 хувиар, сум хөгжүүлэх сангийн орлого 59.7 хувиар тус тус дутуу төвлөрсөн байна.

Хог хаягдлын үйлчилгээний хураамжаас орох орлого өнгөрсөн онд мөн адил 58.9 хувиар тасарсан бөгөөд ЗДТГ-аас хог хаягдлын хураамжийг барагдуулахад анхаарч ажиллахгүй байгааг харуулж байна.

Харин ойн нөөц ашигласны төлбөрийн орлого 22.0 сая төгрөгөөр төлөвлөснөөс 28.9 сая төгрөгт хүрч 6.9 сая, ус рашааны нөөц ашигласны төлбөр төлөвлөснөөс 6.7 сая төгрөгөөр тус тус давж биелсэн нь тус орлогыг бусад татвар хураамжийн орлого дансанд бүртгэж байсныг 2016 оны 4 дүгээр улиралд “Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн хэрэгжилт”-д хийсэн нийцлийн аудитаар татварын нэр төрлийн дагуу төвлөрүүлэх зөвлөмж өгснийг хэрэгжүүлж ажилласантай холбоотой байна.

Орхон сүм: Тайлант онд сумын төсвийн орлогыг 145.0 сая төгрөгөөр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 150.6 сая төгрөг төвлөрч, орлого 103.9 хувийн биелэлттэй байна. Гүйцэтгэлээр хөрөнгө борлуулсаны орлогын албан татвар төлөвлөгөөнөөс 38.7 хувиар, улсын тэмдэгтийн хураамж 85.7 хувиар, байгалийн ургамал ашигласны төлбөрийн орлого 34.5 хувиар тус тус буурсныг 43.4 хувиар давж биелсэн суутган тооцсон татварын орлого, 40.2 хувиар түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр зэрэг нь тодорхой хувиар нөхсөн байна.

Татварын бус орлого тасрахад сум хөгжүүлэх сангийн орлогын төлөвлөгөө 21.7 сая төгрөгөөр дутуу буюу 80.3 хувиар биелсэнтэй холбоотой байна.

Бүлэг 3

Төсвийн зарлагын хэмнэлт ажлын гүйцэтгэл төлөвлөсөн хэмжээнд хүрээгүйгээс үүссэн байна

3.1. Аймгийн ТЕЗ-ийн 2017 оны төсвийн нийт зарлага 71,234.1 сая төгрөгөөр батлагдсанаас гүйцэтгэлээр 64,403.3 сая төгрөг зарцуулж, зардлын гүйцэтгэл 90.4 хувьтай гарчээ. Үүнээс орон нутгийн төсвийн нийт зарлага 37,048.4 сая төгрөгөөр төлөвлөгдсөнөөс 30,314.7 сая төгрөг буюу 81.8 хувийн, тусгай зориулалтын шилжүүлгийн зарлага 34,185.7 сая төгрөгөөр төлөвлөгдсөнөөс 34,088.6 сая төгрөг буюу 99.7 хувийн гүйцэтгэлтэй байна. Нийт зарлагын гүйцэтгэлийн 89.1 хувийг урсгал зардал, 10 хувийг хөрөнгийн зардал, 0.9 хувийг эргэж төлөгдөх зээл буюу сум хөгжүүлэх сангийн зээл эзэлж байна.

Тайлант оны нийт зарлагын гүйцэтгэлийг батлагдсан төлөвлөгөө болон өнгөрсөн оны гүйцэтгэлтэй харьцуулбал:

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	2016 оны гүйцэтгэл	2017 он		Зөрүү		Гүйцэтгэлийн хувь
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	2016 оны гүйцэтгэлээс	Төлөвлөгөө -нөөс	
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	56,484.9	71,234.1	64,403.3	(7,918.4)	6,830.8	90.4
Урсгал зардал	48,835.9	62,754.3	57,368.5	(8,532.6)	5,385.8	91.4
БАҮ-ний зардал	35,446.7	46,634.5	41,792.1	(6,345.4)	4,842.4	89.6
Татаас	3,148.5	3,083.2	3,062.0	86.5	21.2	99.3
Урсгал шилжүүлэг	10,240.7	13,036.6	12,514.4	(2,273.7)	522.2	96.0
Хөрөнгийн зардал	6,660.9	7,519.6	6,464.2	196.7	1,055.4	86.0
Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл	988.1	960.2	570.6	417.5	389.6	59.4

Нийт зардлын гүйцэтгэлийг өнгөрсөн онтой харьцуулахад урсгал зардал 8,532.6 сая төгрөгөөр өссөн бол хөрөнгийн зардал 196.7 сая, эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл 417.5 сая төгрөгөөр тус тус буурчээ. Урсгал зардлын өсөлт нь дараах зардлуудын өсөлттэй холбоотой байна. Үүнд:

- Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардал 5,986.2 сая,
- Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг тусламжийн зардал 1,713.8 сая,
- Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардал 754.0 сая төгрөгөөр тус тус өссөн байна.

Дархан хотын бохир усны менежментийг сайжруулах МОН-3244/3245 төслийн хөрөнгөөр Дархан хотын цэвэрлэх байгууламжийг шинэчлэх, дулааны болон бохирын шугам хоолойг шинээр барих барилга угсралтын ажлын гүйцэтгэлээс шалтгаалан энэ оны төслийн зардал өнгөрсөн оны зардлын гүйцэтгэлээс 5,725.4

сая төгрөгөөр нэмэгдсэн тул бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардал өсчээ.

Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг тусламжийн зардлын өсөлт нь Боловсролын тухай хуульд 43.1.7⁴ дахь заалтыг нэмэлтээр оруулж, хуульд заасан албан тушаалтнуудад олгох тэтгэмжийн 3 дахь удаагийн давтамж тайлант онд тохиолдсонтой холбоотой.

УИХ-аас 2017 оны 67 дугаар тогтоолоор “Төрийн өндөр албан тушаалтан, шүүгч, прокуророос бусад төрийн албан хаагчид 300,000 төгрөгийн ажлын үр дүнгийн урамшуулал олгох” шийдвэр гарсантай холбоотойгоор нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардал өсчээ.

Тайлант оны зардлын гүйцэтгэлийг батлагдсан төлөвлөгөөтэй харьцуулахад 6,830.8 сая төгрөгөөр хэмнэсэн бөгөөд урсгал зардлыг 5,385.8 сая, хөрөнгийн зардлыг 1,055.4 сая, эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл буюу сум хөгжүүлэх сангаас олгох зээлийг 389.6 сая төгрөгөөр төлөвлөсөн зардлаас тус тус дутуу зарцуулсан байна. Урсгал зардлын хэмнэлтэд нөлөөлсөн зардлуудыг нэр төрлөөр авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

- Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлын 4,522.4 сая төгрөгийн хэмнэлт нь Дархан хотын бохир усны менежментийг сайжруулах МОН-3244/3245 төслийн хөрөнгөөр хийгдэх ажлын гүйцэтгэл төлөвлөснөөс дутуу хийгдсэнтэй холбоотой.

- Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн зардал 485.9 сая төгрөгөөр хэмнэгдсэн бөгөөд энэ нь хүнс тэжээлийн дэмжлэг тусламжаа зайлшгүй шаардлагатай нэн ядуу өрх, иргэнд хүнсний эрхийн бичиг олгох босго оноо, сард олгох тэтгэмжийн хэмжээг нэмж баталсантай холбогдуулан төлөвлөгөөг тооцоо судалгаагүй хэт өндөр төлөвснөөс бодит бус хэмнэлт үүсчээ.

- Бараа үйчилгээний бусад зардлын 233.3 сая төгрөгийн хэмнэлт нь Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.3⁵-т заасны дагуу байгалийн аюулт үзэгдэл, гамшигийн үед хохирлыг арилгахтай холбогдсон арга хэмжээг санхүүжүүлэхээр төлөвлөсөн зардлын зарцуулаагүй үлдэгдэл болно.

Хөрөнгийн зардлыг төлөвлөгөөнөөс 1,055.4 сая төгрөгөөр дутуу санхүүжүүлсэн нь хөрөнгө оруулалт, ОНХС-аар хийгдсэн төсөл арга хэмжээний гүйцэтгэл төлөвлөсөн хэмжээнд хүрээгүй, мөн бүрэн хийгдсэн ажлын гүйцэтгэлийн баталгаа болон шилжих хөрөнгө оруулалтаар санхүүжих ажлууд байгаатай холбоотой.

Сум хөгжүүлэх сангаас олгох зээлийн хэмжээ төлөвлөснөөс 389.6 сая төгрөгөөр буурсан нь Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор баталсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”-ын 1.11-т заасан эх үүсвэр бүрдээгүй, 4.2-т заасан шаардлага, 4.3-т заасан шалгуурыг хангасан төсөл ирээгүй зэрэг шалтгаанаас болжээ.

⁴ Сум, тосгон, багийн сургууль, цэцэрлэгийн багшид 5 жил тутамд нэг удаа 6 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийг ажиллаж байгаа байгууллагаас нь олгох;

⁵ Энэ журмын 2.1.1, 2.1.2 дахь хэсэгт заасан хохирлыг арилгахтай холбогдсон арга хэмжээг санхүүжүүлэхэд зориулж нийт батлагдсан хөрөнгийн 30-аас доошгүй хувийг Засаг даргын нөөцөд байлгана.”

3.2. Төсвийн тэнцэл

Тайлант онд орон нутгийн төсвийн зарлага 71,234.1 сая төгрөгийг санхүүжүүлэх эх үүсвэрийг бүрдүүлэхдээ урсгал орлогоос 21,671.4 сая, тусгай зориулалтын шилжүүлгээс 34,185.7 сая, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох орлогын шилжүүлгээс 1,773.3 сая, гадаадын төслийн зээлээс 10,228.2 сая, оны эхний үлдэгдлээс 3,645.9 сая, нийт 71,504.4 сая төгрөг байхаар төлөвлөж, төсвийн тэнцэлийг 270.3 сая төгрөгийн ашигтай байхаар төсөвлөжээ.

Гүйцэтгэлээр 2017 оны орон нутгийн төсвийн тэнцлийн ашиг 270.3 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлж, тайлант оны эцэст орон нутгийн харилцах дансны үлдэгдэл 2,884.2 сая төгрөг болсон байна.

3.3. Нэмэлт санхүүжилт

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар 1,673.5 сая төгрөгийн эх үүсвэр бүрдүүлснээс 1,652.6 сая төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэл 20.9 сая төгрөгийг оны эцэст аймгийн орон нутгийн орлогын дансанд төвлөрүүлжээ. Эх үүсвэрийг орлогын нэр төрлөөр өнгөрсөн оны гүйцэтгэлтэй харьцуулбал:

Үзүүлэлт	Гүйцэтгэл		Зөрүү	
	2016 он	2017 он	Дүн	Хувь
Нэмэлт санхүүжилтийн орлогын дүн	840.4	1,673.5	833.1	199.1
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	128.2	164.2	36.0	128.1
УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ-ын байгууллагаас авах хөнгөлттэй зээл	20.3	29.1	8.8	143.1
ЗГНХ, ЗДНХ-өөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	84.7	180.5	95.8	213.2
Дээд шатны төсвийн захирагчаас доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	353.8	748.6	394.8	211.6
Төсвийн урамшуулал	0.2	-	(0.2)	-
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	253.2	551.1	297.9	217.7

Нэмэлт санхүүжилтийн харилцах дансанд төвлөрсөн орлого өнгөрсөн оноос 2 дахин өсөхөд дараах байгууллагуудын орлогын өсөлт ихээхэн нөлөөлжээ. Үүнд:

- ГХБХБГ-ын газрын нэмэлт санхүүжилтийн орлого өнгөрсөн оны гүйцэтгэлээс 2 дахин өсч, 524.1 сая төгрөгт хүрсэн бөгөөд үүнээс 477.4 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлжээ.

- Шарын гол сумын хүн эмнэлэгт дээд шатны төсвийн захирагчаас нэмэлтээр 194.1 сая төгрөг хуваарилж, тус эмнэлгийн нэмэлт орлого өнгөрсөн оны гүйцэтгэлээс 6.3 дахин өссөн байна. Хуваарилсан хөрөнгөөс бараа үйлчилгээний зардалд 10.8 сая, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн зардалд 65.8 сая, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг тусламжийн зардалд 117.5 сая төгрөг тус тус олгосон байна.

- Хүүхэд, гэр бүл хөгжлийн хэлтэст аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөнөөс

5.5 сая, дээд шатны төсвийн захирагчаас 241.3 сая, төсөвт байгууллагын үйл ажиллагааны нэмэлт орлогоос 6.9 сая, нийт 253.7 сая төгрөгийн нэмэлт санхүүжилтийн орлого төвлөрч, өнгөрсөн оноос 1.5 дахин өссөн байна. Төвлөрсөн орлогыг хүүхэд харах болон хүүхэд хамгааллын үйлчилгээний зардал, “Хүүхэд хөгжлийн ордон”, “Залуучуудын хөгжлийн төв”-ийн урсгал зардлуудыг санхүүжүүлсэн байна.

Аймгийн нэмэлт санхүүжилтийн орлогын 94.7 хувь буюу 1,566.4 сая төгрөгийг урсгал зардалд, 5.3 хувь буюу 86.9 сая төгрөгийг хөрөнгө худалдан авахад зарцуулж, нийт зардалд эзлэх урсгал зардлын хувийн жин өнгөрсөн оныхоос 4.7 хувиар буурч, хөрөнгийн зардал энэ хэмжээгээр өсчээ.

Нэмэлт санхүүжилтийн данснаас зарцуулсан урсгал зардлын 3.2 хувь буюу 50.5 сая төгрөгийг цалин болон түүнтэй холбогдох зардалд, 49.0 хувь буюу 767.7 сая төгрөгийг бараа үйлчилгээний зардалд, үлдсэн 47.8 хувь буюу 748.2 сая төгрөгийг шилжүүлэг хэлбэрээр зарцуулсан байна.

3.4. Тусгай зориулалтын шилжүүлэг

Тусгай зориулалтын шилжүүлгийн нэгтгэсэн тайланд Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын багцын 80, Эрүүл мэндийн сайдын багцын 8, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын болон Барилга, хот байгуулалтын сайдын багцын тус бүр 1, нийт 90 байгууллагын урсгал зардалд 34,185.7 сая төгрөг төлөвлөснөөс гүйцэтгэлээр 34,088.6 сая төгрөг зарцуулж, батлагдсан төсвийг 97.1 сая төгрөгөөр хэмнэсэн байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар дээрх байгууллагуудаас батлагдсан төсвийг хэтрүүлсэн байгууллага байхгүй, “Энэрэл” цогцолбор сургууль болон 1 дүгээр сургууль “Хязгаарлалттай”, бусад байгууллагууд “Зөрчилгүй” санал дүгнэлт өгч, аудитаар доорх алдаа зөрчлүүдийг илрүүллээ. Тухайлбал:

- Урьд онуудад өндөр насны тэтгэвэр тогтоолгох насанд хүрч, тэтгэвэр тогтоолгосон 9, 14, 23 дугаар цэцэрлэгүүдийн эрхлэгч, 11 сургуулийн захирал нарт 87.1 сая төгрөгийн тэтгэвэрт гарахад төрөөс олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж олгосон атлаа одоог хүртэл төрийн албанаас чөлөөлөөгүй. Мөн тайлант онд 18 дугаар цэцэрлэг тэтгэвэрт гарахад төрөөс олгох нэг удаагийн тэтгэмж 16.2 сая төгрөгийг ажилтанд олгосон атлаа тухайн албан тушаалаас чөлөөлөөгүй байсан тул Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 405 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан хаагчид нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам”-ын 2¹-д заасныг хэрэгжүүлж ажиллахыг удирдах дээд албан тушаалтнуудад албан шаардлагаар хүргүүлсэн.

- Аймгийн Засаг даргын захирамжгүйгээр 1, 6, 7, 9, 11, 13, 14, 15, 16, 17, 21, 22 дугаар цэцэрлэгүүд, 30 дугаар сургууль, “Жигүүр” цогцолбор сургууль, Музей, Номын сан зэрэг байгууллагын удирдлагуудад 10.9 сая төгрөгийн ур чадварын нэмэгдэл олгосон тул зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн.

- УИХ-ын 2017 оны 67 дугаар тогтоолын дагуу төрийн өндөр албан тушаалтан, шүүгч, прокуророос бусад төрийн албан хаагчдад үр дүнгийн урамшуулал олгохдоо 9, 11, 16, 23, 24 цэцэрлэгүүд, 1, 9, 11, 14, 30, “Энэрэл” цогцолбор сургуулиуд, Орхон сумын ЭМТ, Биеийн тамир спортын хороо, Музей,

Номын сан зэрэг байгууллагууд Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 52 дугаар хуралдааны тэмдэглэлд заасныг зөрчиж, сахилгын шийтгэлтэй ажилтнуудад нэг удаагийн шагнал, урамшууллын зардалд 5.5 сая төгрөг зарцуулсныг төсөвт буцаан төлүүлэхээр төлбөрийн акт тогтоосон.

- Удирдлага, санхүүгийн ажилтны хариуцлагагүйгээс 3, 4, 5, 10, 12, 23 дугаар цэцэрлэгүүд, 1, 9 дүгээр сургуулиуд, Хүүхдийн номын ордон, Музей, Номын сан зэрэг байгууллагууд 4.4 сая төгрөгийн цалин, нэмэгдэл хөлс, тэтгэмж илүү тооцож олгосныг буруутай албан тушаалтнаар төлүүлэхээр төлбөрийн акт тогтоожээ.

- “Энэрэл” цогцолбор болон 3 дугаар сургуулиуд ажлаас халагдсан ажилтнуудад шүүхийн шийдвэрийг үндэслэн 3.1 сая төгрөг тайлант оны батлагдсан төсвөөс зарцуулсан нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-д заасны дагуу буруутай албан тушаалтнаар төлүүлэхийг удирдах албан тушаалтанд албан шаардлага, зөвлөмжөөр хүргүүлэв.

- Батлагдаагүй орон тоонд хавсран ажиллуулж 3.7 сая төгрөг зарцуулсан 14 дүгээр сургууль, УИХ-ын 2017 оны 29 дүгээр тогтоолыг мөрдөж ажиллаагүйгээс цалингийн шатлал ахиулан 0.3 сая төгрөг олгосон 12 дугаар цэцэрлэг, аймгийн Музейн удирдлагуудад алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмжийг тус тус хүргүүлж ажилласан байна.

Иймд Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хувьд ТШЗ нарт шинээр батлагдсан болон өөрчлөгдсөн хууль тогтоомж, журам зааврын талаарх мэдээллээр хангах, мөрдөж ажиллах үүрэг даалгавар өгөх, санхүүгийн ажилтнуудын мэдлэг чадварыг дээшлүүлэх, чадавхижуулахад анхаарч ажиллах шаардлагатай байна.

3.5. Улсын төсвийн хөрөнгөөр хийгдсэн хөрөнгө оруулалт

Дархан-Уул аймагт 2017 онд 3 салбарт нийт 4,313.2 сая төгрөгийн төсөвт өртөлтэй 7 ажлыг улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр аймгийн Засаг даргад эрх шилжүүлснээс гүйцэтгэлээр 4,283.3 сая төгрөг зарцуулж, батлагдсан төсвийг 29.9 сая төгрөгөөр хэмнэжээ. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлуудын гүйцэтгэлийг төсөл арга хэмжээ бүрээр задалбал:

- "Дулаан Шарын гол" ТӨХК-ийн Дулааны станцаас дулаан хувиарлах төв хүртэлх гадна дулааны 2.2 км төв шугамын өргөтгөл, шинэчлэлд 3,888.0 сая төгрөг зарцуулж, батлагдсан төсвийг 10.1 сая төгрөгөөр,
- "Од" цогцолбор сургуулийн барилгын дээврийн засварт 85.2 сая төгрөг зарцуулж, батлагдсан төсвийг 14.8 сая төгрөгөөр,
- Шарын гол сумын 2 дугаар цэцэрлэгийн барилгын өргөтгөлд 98.4 сая төгрөг зарцуулж, батлагдсан төсвийг 1.6 сая төгрөгөөр,
- "Оюуны Ирээдүй" цогцолбор сургуулийн "А" байрны дээврийн засварт 69.9 сая төгрөг зарцуулж, батлагдсан төсвийг 0.1 сая төгрөгөөр,
- Нэгдсэн эмнэлгийн сэтгэц, нарклогийн тасгийн барилгын дээврийн засварт 53.0 сая төгрөг зарцуулж, батлагдсан төсвийг 2.1 сая төгрөгөөр,
- 1 дүгээр сургуулийн гадна цэвэр усны шугам, спорт заалны засварт 49.5 сая төгрөг зарцуулж, батлагдсан төсвийг 0.5 сая төгрөгөөр,

- 18 дугаар сургуулийн дулааны узель, ялтсан дулаан солилцуурын засварт 39.3 сая төгрөг зарцуулж, батлагдсан төсвийг 0.7 сая төгрөгөөр тус тус хэмнэсэн байв.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл арга хэмжээний хувьд аймгийн Засаг дарга худалдан авах ажиллагааг үр нөлөөтэй зохион байгуулснаас гадна гүйцэтгэгч компанитай байгуулсан ажил гэрээт хугацаандаа бүрэн хийгдэж, үр дүнтэй хэрэгжсэн байна.

3.6. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн талаар

Тайлант онд Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газраас Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасны дагуу хяналт тавихад 18 байгууллага дээрх хуулийн 6 дугаар зүйлд заасан зарим мэдээллийг бүрэн байршуулаагүй байлаа. Үүнд:

- “Энэрэл” цогцолбор сургууль тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4⁶-т заасан 5 саяас дээш үнийн дүн бүхий худалдан авалтын 30.5 сая төгрөгийн 2 гүйлгээг мэдээлээгүй,
- Орон нутгийн 5 байгууллага, тусгай зориулалтын шилжүүгийн 6 байгууллага уг хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5⁷-д цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 823.8 сая төгрөгийн орлогын 32, 563.0 сая төгрөгийн зарлагын 32 гүйлгээг тус тус байршуулаагүй,
- Байгаль орчин аялал, жуулчлалын газар болон тусгай зориулалтын шилжүүгийн 6 байгууллага хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8⁸-д заасан төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах 404.5 сая төгрөгийн 43 шийдвэрийг мэдээлээгүй зэрэг зөрчил илэрсэн байна.

Дээрх зөрчлийг арилгах хугацаатай албан шаардлага өгч биелэлтийг бүрэн хангуулсан бөгөөд дээрх байгууллагын нягтлан бодогч нарт хуулийн дагуу сахилгын хариуцлага тооцуулсан.

Мөн аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба дээрх хуулийн 8 дугаар зүйлийн 8.2⁹-д заасны дагуу шилэн дансны үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг хэрэгжүүлсэн байлаа.

Тус албанаас аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад харьяалагдах байгууллагуудын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг 2017 оны 1, 2 дугаар улирлыг хамруулан шалгаж, хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллүүдийг байршуулахдаа хугацаа хоцроосон, 2 дугаар улирлын тайланг илгээгээгүй байгууллагын төсвийн шууд захирагч нарт аймгийн Засаг даргын 2017 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн А/419 дугаар захирамжаар сахилгын шийтгэл ногдуулсан байна.

⁶ Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг

⁷ Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр

⁸ Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр

⁹ Энэ хуулийн 3.1.1-д заасан төсвийн байгууллага, албан тушаалтны шилэн дансны үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагч хэрэгжүүлнэ

Дүгнэлт

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.

1. Аймгийн төсөвт төвлөрөх татварын орлогын төлөвлөгөөг 102.6 хувиар биелүүлсэн байна.
2. Дархан-Уул аймгийн ТЕЗ-ийн төсвийн гүйцэтгэл 6,830.7 сая төгрөгийн хэмнэлттэй зарцуулагджээ.

Зөвлөмж

Аудитын дүнд үндэслэн аймгийн Засаг дарга буюу Төсвийн ерөнхийлөн захирагч С.Насанбат, Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга Б.Жаргалсайхан нарт зөвлөх нь:

- Татварын зарим нэр төрлийн орлого тасарсан шалтгааныг нарийвчлан тогтоож, цаашид бүрэн биелүүлэх талаар анхаарч, татварын орлогыг нэр төрлөөр жигд ханган биелүүлэх.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 4 дүгээр улиралд багтаан аймгийн Аудитын газар ирүүлэх.

ХЯНАСАН:

Тэргүүлэх аудитор

Ч.Чүлтэмбат

Аудитын менежер

Ш.Мөнхбаяр

ТАЙЛАНГ ХЯНАСАН:

Ахлах аудитор

Х.Сувдмаа

Аудитор

У.Батсүрэн



МОНГОЛ УЛС
ДАРХАН-УУЛ АЙМАГ
ЗАСАГ ДАРГА

45059 Дархан, Дархан-Уул аймаг,
Утас: 7037-8023, Факс: 7037-7121,
И-мэйл: info@darkhan.gov.mn
Вэбсайт: www.darkhan.gov.mn

2018.04.17 № 1-10/307
танай 2018.04.16-ны № 254 -Т

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ДАРГА Ч.ЧҮЛТЭМБАТ ТАНАА

Аймгийн 2017 оны нэгдсэн төсвийн санхүүгийн
нэгтгэсэн тайлангийн гүйцэтгэлд хийсэн аудитын
зөвлөмжийн төсөлтэй танилцлаа.

Зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллах болно.

ДАРГА  С.НАСАНБАТ

1001F12918433



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 04 дугаар сарын 20

№ А/04

Дархан-Уул аймаг

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Монгол Улсын Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5, Ерөнхий аудиторын 2017 оны А/188 дугаар тушаалаар баталсан "Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторт шилжүүлэх бүрэн эрх"-ийн 2.4, "Гүйцэтгэлийн аудитын журам"-ын 12.40 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Үндэсний аудитын газрын нэгдсэн төлөвлөгөө, аймгийн Аудитын газрын 2018 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу "Дархан-Уул аймгийн 2017 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл"-д хийсэн аудитын тайланг баталгаажуулсугай.

2. Аудитын тайланг аймгийн ИТХ-ын дарга Г.Эрдэнэбат, Засаг дарга С.Насанбат нарт хүргүүлж, тайланд дурьдагдсан зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, биелэлтийг 2018 оны 12 дугаар сарын 01-ний дотор аймгийн Аудитын газарт ирүүлэхийг зөвлөсүгэй.

3. Аудитын тайланд тусгагдсан зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ахлах аудитор С.Батцэцэгт үүрэг болгосугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.ЧҮЛТЭМБАТ



000296

D:\bichig heregt\TUSHAAL.docx